



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дорноговь аймгийн Мандах сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДГА-2020/12/СТА-ТТЗ

<p>Цахим хуудас: www.dornogovi.audit.mn Дорноговь аймаг 2020 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Ариунаа Утас: 70522734 Цахим хаяг: dornogovi@audit.gov.mn Аудитын менежер: Ч.Хэрлэнчимэг Утас: 70523020 Цахим хаяг: kherlenchimegch@audit.gov.mn Аудитор: Т.Мөнхтогтох Цахим хаяг: munkhtogtokht@audit.gov.mn</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын гэрчилгээ	2
2. Аудитын тайлан	4
2.1. Оршил.....	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	5
2.5. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	5
2.6. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	5
2.7. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	5
2.8 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт	6
2.8.1 Мөнгөн хөрөнгө	6
2.8.2 Авлага.....	6
2.8.3 Бараа материал	7
2.8.4 Үндсэн хөрөнгө	7
2.8.5 Өр төлбөр.....	8
2.8.6 Засгийн газрын хувь оролцоо.....	9
2.9 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	9
2.10. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	10
2.11. Шилэн дансны мэдээлэл	10
2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	10
2.13. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	10
3. Менежментийн захидал.....	12
3.1 Төсвийн өмнө хүлээсэн үүргийн биелэлттэй холбоотой асуудал	12
4. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	13
4.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан.....	13
4.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан.....	15
4.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	18
4.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	21
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	22
4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	24
5.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	25

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч

1. Аудитын гэрчилгээ



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,
3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр,
Утас: (705) 2-27-34
Вэб сайт: dornogovi@audit.gov.mn

2020.03.25 № 1-6/352

танай _____ -ны № _____ -т

МАНДАХ СУМЫН ЗАСАГ
ДАРГА Н.ОТГОНБАЯР ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-д заасны дагуу Мандах сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Мандах сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Мандах сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Мандах сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.АРИУНАА

2. Аудитын тайлан

2.1. Оршил

Мандах сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн төвлөрүүлэн захирагч Мандах сумын Засаг дарга Н.Отгонбаяр танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-т заасны дагуу Мандах сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Мандах сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 03 дугаар сарын 06-аас 2020 оны 03 дугаар сарын 11-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 03 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Т.Мөнхтогтох хариуцаж хэрэгжүүлэв.

Мандах сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн 5/63 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэн, шат шатны чанарын хяналт хийж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитыг Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болгож, батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлэв.

2.4. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Мандах сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох стандарт, журмын дагуу шинэчлэгдсэн байна.

Мандах сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй гэж үзлээ.

2.5. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Мандах сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 2 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 2 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.6. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Нийт зардлыг сонгов.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын түвшнийг 829.8 сая төгрөгийн 1 хувь буюу 8.2 сая төгрөгөөр тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 20.8 сая төгрөгөөр тогтоосон нь ажил гүйлгээний цар хүрээ багатай холбоотой болно.

2.7. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 6 төсвийн байгууллага, 3 тусгайн сангийн нийт 9 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 2 байгууллагад санал дүгнэлт гаргах, 3 байгууллагад түүвэр аудит, 1 байгууллагад итгэл үзүүлж, 3 санд түүвэр аудитад хийсэн.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд “Зөрчилгүй” 2 өгсөн байна. “Хязгаарлалттай”, “Сөрөг”, “Санал дүгнэлтээс татгалзсан” дүгнэлт авсан байгууллага байхгүй байна.

Мандах сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 238.1 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 237.4 сая төгрөгийн 3 алдааг аудитын явцад залруулж, 0.7 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 4 зөвлөмжийг хүргүүлсэн.

Төвлөрүүлэн захирагчийн алдаа, зөрчилд өгсөн 1 зөвлөмжийг менежментийн захидалд дурдсан болно.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн залруулга

Тус төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд нийт 237.4 сая төгрөгийн залруулга хийлээ. Тухайлбал:

- Ерөнхий боловсролын сургууль - 16.7 сая төгрөгийн гүйлгээг тооцооны дансаар дамжуулалгүй зардалд шууд бичсэн, 67.8 сая төгрөгийн дансны бичилт буруу хийсэн.
- Орон нутгийн хөгжлийн сан – 5 төсөл арга хэмжээ ажил нь хийгдэж, комисс хүлээж авсан. Нийт дутуу 152.6 сая төгрөгийн санхүүжилтийг олгоогүй боловч Санхүүгийн тайланд өглөг, авлагаар бүртгээгүй байсныг залруулсан.
- Сум хөгжүүлэх сан – Санхүүгийн тайланд 0.3 сая төгрөгийн зээлийн авлагыг илүү тооцсоныг аудитын явцад залруулсан.

2.8 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

2.8.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 141.9 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 135.2 сая төгрөг болж 6.7 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №1 Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Касст байгаа бэлэн мөнгө				
Банканд байгаа бэлэн мөнгө	141.9	135.2	-6.7	95.2
Замд яваа мөнгөн хөрөнгө				
Хадгаламж				
Дүн	141.9	135.2	-6.7	95.2

Эх сурвалж: Мандах сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд байгаа 135.2 сая төгрөг нь Ерөнхий боловсролын сургуулийн Ахмадын сан 7.4 сая төгрөг, Орон нутгийн хөгжлийн сан 25.1 сая төгрөг, Сум хөгжүүлэх сан 71.1 сая төгрөг, Нөхөн сэргээлтийн сан 25.3 сая төгрөг, Засаг даргын Тамгын газрын нэмэлт санхүүжилт 6.3 сая төгрөг байна.

2.8.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 137.1 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 306.2 сая төгрөг болж, 169.1 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №2 Авлагын үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	0.2		-0.2
Төлбөртэй үйлчилгээний авлага			
Татаас, санхүүжилтийн авлага			
Зээлийн хүүгийн авлага		0.6	0.6
Бусад авлага	13.2	158.9	145.7
Зээлийн авлага	123.7	146.7	23.0
Дүн	137.1	306.2	169.1

Эх сурвалж: Мандах сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлага дансны үлдэгдэлд Засаг даргын Тамгын газрын нэмэлт санхүүжилт байгууллагаас авах авлага 6.2 сая төгрөг, Сум хөгжүүлэх сангийн 147.3 сая төгрөг, Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтийн авлага 152.7 сая төгрөг байна.

2.8.3 БАРАА МАТЕРИАЛ

Бараа материалын эхний үлдэгдэл 153.9 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 199.6 сая төгрөг болж, 45.7 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №3 Бараа материалын үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Тусгай зориулалттай материал	19.1	22.7	3.6
Эм боох материал	4.8	14.4	9.6
Бэлэн бүтээгдэхүүн			
Бичиг хэргийн материал	5.5	8.6	3.1
Аж ахуйн материал	85.0	102.5	17.5
Түлш шатах тослох материал	23.6	34.1	10.5
Сэлбэг хэрэгсэл	1.3	1.3	0
Хүнсний материал	13.1	14.5	1.4
Бусад хангамжийн материал			
Мал амьтад	1.5	1.5	0
Дүн	153.9	199.6	45.7

Эх сурвалж: Мандах сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын дансны үлдэгдэлд Иргэдийн Төлөөлөгчдийн хурал 2.5 сая төгрөг, Засаг даргын Тамгын газар 49.3 сая төгрөг, Ерөнхий боловсролын сургууль 47.1 сая төгрөг, Хүүхдийн цэцэрлэг 38.3 сая төгрөг, Эрүүл мэндийн төв 49.1 сая төгрөг, Соёлын төв 13.3 сая төгрөг байна.

2.8.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 3,396.2 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 4,911.5 сая төгрөг болж, 1,515.3 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №4 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Барилга, байгууламж, орон сууц	2,618.0	3,907.9	1,289.9
Хуримтлагдсан элэгдэл	-308.1	-383.5	-75.4
Авто тээврийн хэрэгсэл	203.4	262.5	59.1
Хуримтлагдсан элэгдэл	-143.3	-158.8	-15.5
Машин тоног төхөөрөмж	430.7	487.5	56.8
Хуримтлагдсан элэгдэл	-282.8	-271.9	10.9
Тавилга, аж ахуйн эд хогшил	180.7	185.9	5.2
Хуримтлагдсан элэгдэл	-100.4	-98.6	1.8
Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	0.5	0.5	0
Зам гүүрийн байгууламж	146.2	146.2	0
Бусад үндсэн хөрөнгө	836.3	1,062.7	226.4
Хуримтлагдсан элэгдэл	-230.4	-295.1	-64.7
Ном	21.3	20.2	-1.1
Програм хангамж	3.8	3.8	0
Хуримтлагдсан элэгдэл	-2.9	-3.2	-0.3
Бусад биет бус хөрөнгө	23.2	45.4	22.2
Дүн	3,396.2	4,911.5	1,515.3

Эх сурвалж: Мандах сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 49.4 сая төгрөг, балансаас балансад шилжүүлэн авсан 31.6 сая төгрөг, үнэ төлбөргүй хандиваар 1,672.1 сая төгрөгөөр нэмэгдсэн, балансаас балансад шилжүүлсэн 1.2 сая төгрөг, акталсан 93.2 сая төгрөгөөр хасагдсан байна.

2.8.5 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 7.0 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 158.8 сая төгрөг болж, 151.8 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №5 Нийт өр төлбөрийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Ажилчидтай холбогдсон өглөг	0.1	0	-0.1	0
Байгууллагад төлөх өглөг	6.9	158.8	151.9	2268
Хувь хүмүүст төлөх өглөг				
Дүн	7.0	158.8	151.8	2268

Эх сурвалж: Мандах сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Өр төлбөр дансны үлдэгдэлд Орон нутгийн хөгжлийн сангийн 152.6 сая төгрөг, Засаг даргын Тамгын газрын нэмэлт санхүүжилтийн 6.2 сая төгрөг байна.

2.8.6 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 3,830.4 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 5,404.7 сая төгрөг болж, 1,574.3 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №6 Засгийн газрын хувь оролцоо /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,410.6	1,432.8	22.2	101.5
Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/				
Хуримтлагдсан үр дүн	1,569.5	3,121.7	1,552.2	198.8
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	850.3	850.2	-0.1	0
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				
Бодлогын өөрчлөлт алдааны залруулга				
Дүн	3,830.4	5,404.7	1,574.3	300.3

Эх сурвалж: Мандах сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын оруулсан капитал данс өөрчлөгдсөн нь Хүүхдийн цэцэрлэг шинэ цэцэрлэгийн барилгатай болж 22.2 сая төгрөгийн газрыг орлогодож авсан.

Бодлогын өөрчлөлт алдааны залруулга хийгдээгүй.

2.9 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Мандах сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2019 оны Нэмэлт өөрчлөлт оруулсан төсөв батлах тухай 10/01 дүгээр тогтоолд зааснаар Мандах сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн тайлант онд 54.4 сая төгрөгийн орлого орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 84.0 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 154 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт №7 Төвлөрүүлэх орлого

/сая төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Үйл ажиллагааны орлого	0.9	1.9	-1.0	237
Хадгаламжийн хүүгийн орлого	8.9	14.8	-5.9	166
Хувь хүнээс суутгасан орлогын албан татвар	10.3	16.0	-5.7	155
Хөрөнгө борлуулсны орлого	0.1	0.1	0.0	100
Бууны татвар	1.9	1.9	0.0	100
Улсын тэмдэгтийн хураамж	1.2	9.3	-8.1	775
Ан амьтны нөөц ашигласны төлбөр	26.9	29.8	-2.9	110
Хог хаягдлын төлбөр	4.0	8.6	-4.6	215
Түгээмэл тархацтай ашигт малтмал	0.1	0.1	0	100
Хүү торгууль	0.1	1.5	-1.4	1500
Нийт дүн	54.4	84.0	-29.6	154

Үйл ажиллагааны орлого 1.0 сая төгрөгөөр давсан нь үйл ажиллагаа эрхлэгч иргэдийн тоо нэмэгдсэн, хадгаламжийн хүүгийн орлого 5.9 сая төгрөг давсан нь хадгаламж эзэмшигч иргэдийн тоо нэмэгдсэн, хувь хүнээс суутгасан орлогын албан татвар 5.7 сая төгрөг давсан нь НӨАТ-ын урамшууллын систем болон 2018 оны ноосны урамшууллаас шалтгаалсан, улсын тэмдэгтийн хураамж 8.1 сая төгрөгөөр давсан нь ангийн зөвшөөрлийн улсын тэмдэгтийн хураамж тухайн харьяалах нутаг дэвсгэрт ордог болсноос давсан, хог хаягдлын төлбөр 4.6 сая төгрөг давсан нь суманд үйл ажиллагаа явуулдаг иргэд аж ахуйн нэгжийг бүрэн хамруулсан, хүү торгуулийн орлого 1.4 сая төгрөг давсан нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх аяны хүрээнд зөрчил дутагдлын илрүүлэлт нэмэгдсэн зэргээс тус тус шалтгаалсан байна.

Тайлант онд Төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 8 хөтөлбөрт зориулан 2,024.1 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 1,472.2 сая төгрөгийг урсгал зардалд, 551.9 сая төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 477.6 сая төгрөгийг орон нутгийн төсвийн орлогоос, 847.6 сая төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээс, 16.0 сая төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас, 527.3 сая төгрөгийг орон нутгийн хөгжлийн сангаас, 155.6 сая төгрөгийг туслах үйл ажиллагааны орлогоос, нийт 2,024.1 сая төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 470.5 сая төгрөгийг, тусгай зориулалтын шилжүүлгээс 838.4 сая төгрөг, Эрүүл мэндийн даатгалын сангаас 15.9 сая төгрөгийг, орон нутгийн хөгжлийн сангас 370.9 сая төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос 82.8 сая төгрөг, нийт 1,778.5 сая төгрөгийн санхүүжилтийг бүрэн олгосон байна.

Туслах үйл ажиллагааны орлого 0.9 сая төгрөг бүрдүүлж, батлагдсан төсвөөс 0,1 сая төгрөгөөр тасарсан нь Засаг даргын Тамгын газрын гэр буудалд буух үйлчлүүлэгч багассанаас шалтгаалжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Хөрөнгө оруулалтын 2019 оны төсөл, арга хэмжээнд 551.9 сая төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 370.4 сая төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,791.9 сая төгрөг буюу 88.5 хувьтай байна.

Нэмэлт төсөв: Дээд шатны төсвийн захирагчаас Иргэдийн Төлөөлөгчдийн хурал 0.2 сая төгрөг, Засаг даргын Тамгын газар 26.9 сая төгрөг, Эрүүл мэндийн төв 2.2 сая төгрөг, Соёлын төв 0.8 сая төгрөг, Ерөнхий боловсролын сургууль 1.2 сая төгрөг нийт 31.3 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс: Иргэдийн Төлөөлөгчдийн хурал 0.2 сая төгрөг, Засаг даргын Тамгын газар 20.6 сая төгрөг, Эрүүл мэндийн төв 2.2 сая төгрөг, Соёлын төв 0.8 сая төгрөг, Ерөнхий боловсролын сургууль 1.2 сая төгрөг, нийт 25.0 сая төгрөгийг зарцуулж, Засаг даргын Тамгын газрын үлдэгдэл 6.3 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

2.10. ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

2.11. Шилэн дансны мэдээлэл

Мандах сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 148 мэдээллийг хугацаанд нь, 1 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, огт байршуулаагүй мэдээлэл байхгүй байна.

Төсөв гүйцэтгэл, хөрөнгө оруулалт, худалдан авалт, бусад гэх мэт мэдээллүүдийг хуулийн хугацаанд байршуулсан байна.

2.12. ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 9.1 сая төгрөгийн зөрчлийг арилгах 1 албан шаардлага хүргүүлж, албан шаардлагыг хэрэгжүүлсэн байна.

Нийт 3 зөвлөмж өгснөөс 3 зөвлөмжийг хэрэгжүүлж, зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

2.13. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Мандах сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Мандах сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн нэгтгэсэн үр дүн, нэгтгэсэн мөнгөн гүйлгээ, нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Мандах сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн нэгтгэсэн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Төсвийн өмнө хүлээсэн үүргийн биелэлттэй холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт: Засаг даргын нөөц хөрөнгөөс 3.7 сая төгрөгийг зарцуулахдаа 6 захирамж гаргасан бөгөөд захирамжийн үндэслэх хэсэгт хүчингүй болсон Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалыг үндэслэл болгосон.

3.1.2 Эрсдэл: Шинэчлэн баталсан журам мөрдөгдөхгүй байх

3.1.3 Өгсөн зөвлөмж: Хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Сангийн сайдын 2018 оны 318 дугаар “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын холбогдох заалтыг үндэслэн төсвийг зарцуулах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 05 дугаар сарын 25-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	441,245.2	652,105.2
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	141,940.2	135,241.0
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	141,940.2	135,241.0
31210	Төгрөг	141,940.2	135,241.0
31211	Төрийн сангийн харилцах	141,940.2	135,241.0
33	АВЛАГА	137,077.2	306,253.3
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	250.1	-
33400	Зээлийн хүүгийн авлага	-	642.4
33500	Бусад авлага	13,165.5	158,893.8
33510	Байгууллагаас авах авлага	13,165.5	158,893.8
33600	Зээлийн авлага	123,661.7	146,717.1
33610	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага	123,661.7	146,717.1
33612	Хувь хүмүүст олгосон зээл	123,661.7	146,717.1
35	БАРАА МАТЕРИАЛ	153,949.8	199,695.9
35100	Түүхий эд материал	23,918.9	37,101.8
35110	Тусгай зориулалттай материал	19,095.4	22,710.4
35130	Эм боох материал	4,823.5	14,391.4
35400	Хангамжийн материал	128,515.7	161,078.9
35410	Бичиг хэргийн материал	5,475.2	8,576.2
35420	Аж ахуйн материал	85,081.4	102,556.4
35430	Сэлбэг хэрэгсэл	1,270.0	1,270.0
35440	Түлш, шатах тослох материал	23,556.0	34,108.1
35460	Хүнсний материал	13,133.1	14,568.3
35600	Мал амьтад	1,515.2	1,515.2
36	НӨӨЦИЙН БАРАА	8,278.0	10,915.0
36600	Бусад нөөц	8,278.0	10,915.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	3,396,223.4	4,911,564.8
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,396,223.4	4,911,564.8
39200	Биет хөрөнгө	3,372,105.4	4,865,527.8
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,618,034.2	3,907,978.8
39202	Хуримтлагдсан элэгдэл	(308,070.3)	(383,541.7)
